

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

***ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
ГАЗАРДУУЛГЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

**Тендер  
шалгаруулалтын нэр  
/дугаар:**

***Холбоо, навигаци, ажиглалтын албаны тоног  
төхөөрөмжийн газардуулгын материал нийлүүлэх  
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер.  
ИНЕГ/УЗ/ТББ/Б-17/20***

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.04.21

Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Холбоо, навигаци, ажиглалтын албаны тоног төхөөрөмжийн газардуулгын материал ИНЕГ/УЗ/ТББ/Б-17/20-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 04-р сарын 28-ны 09.00 цаг-аас өмнө Засгийн газрын худалдан авах цахим систем /[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)/ цахим хуудсанд цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 04-р сарын 28-ны өдрийн 09.30 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар болон [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудаснаас авч болно.

Улаанбаатар хот. Буянт-Ухаа. Иргэний нисэхийн ерөнхий газар.

ХААТасаг. 108 тоот өрөө.

Утас: 71-282163

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт  |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1                | <ol style="list-style-type: none"> <li>1. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: /Төсөвт өртгийн 50%-тай тэнцүү дүнгээр ирүүлнэ/</li> <li>2. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил.</li> <li>3. Тусгай зөвшөөрөл шаардлагагүй.</li> </ol>  |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:<br/>                     Байгууллагын хаяг: <b>[Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар]</b><br/>                     Давхар болон өрөөний дугаар: <b>[Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот]</b><br/>                     Огноо: <b>[2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр]</b><br/>                     Цаг: <b>[09 цаг 00 минут]</b></p>   |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:<br/>                     Байгууллагын хаяг: <b>[Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар]</b><br/>                     Давхар болон өрөөний дугаар: <b>[Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот]</b><br/>                     Огноо: <b>[2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр]</b><br/>                     Цаг: <b>[09 цаг 30 минут]</b></p>   |
| ТӨӨЗ 2.3                | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>2. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>3. Нийгмийн даатгалын өр төлбөргүй талаарх цахим тодорхойлолт</li> <li>4. Татварын албаны цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх/</li> <li>5. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> </ol> |
| ТӨӨЗ 6.2                | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[Холбоо, навигац, ажиглалтын албаны тоног төхөөрөмжийн газардуулгын материал ИНЕГ/УЗ/ТББ/Б-17/20]</b></p>  |

Дөрөв: **БАРАА НИЙЛҮҮЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**АГУУЛГА**

1. Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарь
2. Холбогдох үйлчилгээний жагсаалт болон гүйцэтгэлийн хуваарь
3. Техникийн тодорхойлолт

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

| д/д      | Материалын нэр  | Хэмжих нэгж                                   | Нийт Орц | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа |                          |                                      |
|----------|---|---|----------|--|---|--------------------------|--------------------------------------|
|          |   |   |          |  | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа                               | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| <b>1</b> | 70мм2 огтлолтой зэс бүрээстэй ган шин   | метр  | 600      | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 1.1      | Зузаан  | мм  | 4        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 1.2      | Өргөн   | мм  | 30       | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| <b>2</b> | Зэс бүрээстэй ган полоса төмөр тор / 4-9 нүдтэй/  | м2  | 13       | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 2.1      | Торны хэмжээ 2x1 метр 6 нүдтэй  | ширхэг  | 2        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 2.2      | Торны хэмжээ 1x1 метр 4 нүдтэй  | ширхэг  | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 2.3      | Торны хэмжээ 2x1.5 метр 6 нүдтэй  | ширхэг  | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 2.4      | Торны хэмжээ 2x2.5 метр 9 нүдтэй  | ширхэг  | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| <b>3</b> | Газардуулгыг тоног төхөөрөмжтэй холбох төгсгөвч   | ширхэг  | 15       | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 3.1      | Төгсгөвчийн урт   | мм  | 95       | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 3.2      | Хийцийн материал  | Зэс эсхүл зэс бүрээстэй ган төгсгөвч          |          |  |   |                          |                                      |
| <b>4</b> | Электрод э-46   | кг  | 25.2     | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| <b>5</b> | Эсэргүүцэл бууруулагч бодис   | кг  | 3000     | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 5.1      | Хэвтээ газардуулгын системийн хөрсний хүчил шүлтэнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, хамгаалах, цахилгаан гүйдэл дамжуулах чадварыг дээшлүүлэх, газардуулгын эсэргүүцэл буулгах бодис |   |          |  |   |                          |                                      |
| 5.2      | Хийцийн материал  | Химийн гаралтай эсэргүүцэл бууруулах бодисууд |          |  |   |                          |                                      |
| <b>6</b> | Гагнуурын Т,Х,Г хэлбэрийн хэв /"Т", "+", "-", "Δ" тэслэгийн хэв агуулсан/   | ком   | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 6.1      | Хэвний хавчаар  | Ширхэг  | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 6.2      | Тэслэгчийн буу  | ширхэг  | 1        | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 6.3      | Тэслэгч бодис /Газардуулгын системийн гадас, шин /полоса/, зэс утсыг холбож гагнах бараа материал/  | ширхэг  | 180      | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| <b>7</b> | Зэс бүрээстэй ган гадас Ø14.2 мм  | ширхэг  | 180      | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 7.1      | Гадасны диаметр   | 14.2 мм                                       |          | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 7.2      | Гадасны урт   | 1.5 метр                                      |          | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 7.3      | Гадасны хоёр үзүүрийн резьба /толгой, хошуу залгах/   | 100мм   |          | Инег                                   | 30  | 45                       |                                      |
| 7.4      | Хийцийн материал  | Зэс эсхүл зэс бүрээстэй ган гадас             |          |  |   |                          |                                      |

|           |   |        |     |      |    |    |  |
|-----------|---|--------|-----|------|----|----|--|
| <b>8</b>  | Гадасны холбогч<br>/14.2мм диаметртэй 1.5 метр<br>урттай 2 гадсыг хооронд нь<br>холбох, зэс ган хийцтэй<br>байна./                                | ширхэг | 108 | Инег | 30 | 45 |  |
| <b>9</b>  | Гадасны толгой<br>/14.2мм диаметртэй 3<br>метрийн урттай гадасны дээд<br>үзүүрт холбож газарт зоох<br>цохилтыг даах ган хийцтэй<br>байна./        | ширхэг | 90  | Инег | 30 | 45 |  |
| <b>10</b> | Гадасны хошуу<br>/14.2мм диаметртэй 3<br>метрийн урттай гадасны доод<br>үзүүрт холбож газарт зоох<br>боломжтой сайжруулсан ган<br>хийцтэй байна./ | ширхэг | 90  | Инег | 30 | 45 |  |



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо барих<br>хаяг/утас/факс | Гэрээний үнийн<br>дүн | Гэрээний эхлэх<br>хугацаа | Гэрээний<br>дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1.           |  |                       |                           |                            |
| 2.           |  |                       |                           |                            |
| 3.           |  |                       |                           |                            |
| 4.           |  |                       |                           |                            |
| 5.           |  |                       |                           |                            |
| бусад.       |  |                       |                           |                            |

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[Шаардлагагүй]</b> жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[30]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Иргэний нисэхийн ерөнхий газраас ажлын комисс томилон барааг хүлээж авна  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 3.1. Баталгаат засвар шаардлагагүй<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>2. Ирсэн барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гүйцэтгэлээр төлбөрийг төлнө.   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | 5.1. Алданги оногдуулах хувь: <b>[Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%]</b><br>5.2. Алдангийн нийт дүн: <b>[Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%]</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

| ЗАХИАЛАГЧ       | НИЙЛҮҮЛЭГЧ      |
|-----------------|-----------------|
| _____           | _____           |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____           | _____           |
| (Гарын үсэг)    | (Гарын үсэг)    |
| _____           | _____           |
| (Албан тушаал)  | (Албан тушаал)  |

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*